



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2024 оны 11 сарын 25 өдөр

Дугаар 8/40

Улаанбаатар хот

Г Журам батлах тухай Т

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 25 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, 2019 оны 472 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт, Эмнэлгийн тусlamж үйлчилгээний тухай хуулийн 22 дугаар зүйл, Эрүүл мэндийн тухай хуулийн 28 дугаар зүйл, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/226 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Резидент эмчийн ажиллан суралцах журмыг хавсралтаар баталсугай.
2. Резидент эмчтэй хөдөлмөрийн гэрээ, албан тушаалын тодорхойлолтыг тухай бүрт байгуулж ажиллахыг Хүний нөөцийн ажилтан (Б.Отгоннавс)-д даалгасугай.
3. Резидент эмчийн ажиллан суралцах журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл технологийн албаны дарга (Д.Алтантогтох)-д үүрэг болгосугай.
4. Резидент эмчид олгох цалингийн санг сургалтын багтаамжтай уялдуулан жил бүр төсөвт тусгуулахыг Эдийн засагч (П.Отгонбаатар), Сургалтын менежер (П.Алтангэрэл) нарт тус тус даалгасугай.
5. Резидент эмчийн цалинг тогтоосон хугацаанд олгохыг Санхүү, эдийн засаг, хангамж үйлчилгээний албаны дарга, ахлан нягтлан бодогч (З.Ууганцэцэг)-д зөвшөөрсүгэй.
6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд захирал (Б.Амгаланбаяр)-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Н.ЦОГБАДРАХ



Төвийн ерөнхий захирлын

2021 оны 11. дүгээр сарын 25.-ны өдрийн

Ажиллаар тушаалын хавсралт

TT35150-00092005

РЕЗИДЕНТ ЭМЧИЙН АЖИЛЛАН СУРАЛЦАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь тус төвд резидент эмчийн, ажиллах, суралцах үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Резидент эмч гэж үндсэн мэргэшил эзэмшихээр Эрүүл мэндийн сайдын тушаалаар нэр нь батлагдсан мэргэжилтнийг хэлнэ.

1.3. Зоонозын өвчин судлал үндсэн мэргэшлийн сургалт нь резидент эмчид тухайн мэргэшлийн чиглэлээр дагнан ажиллах эмнэл зүй, тархвар судлалын мэдлэг, ур чадвар, хандлага эзэмшүүлэхэд чиглэгдэнэ.

1.4. Резидент эмчийн ажиллан суралцах харилцаа нь Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомж түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журмын хүрээнд зохицуулагдана.

1.5. Резидент эмчтэй байгуулах хөдөлмөрийн гэрээнд Хөдөлмөрийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заасан гол нөхцөл болон резидент эмчийн аюулгүй байдал, эрүүл ахуй, резидент эмч, эмнэл зүйн сургагч багш, бусад талын эрх, үүрэг, оролцоо, хариуцлагыг тусгана.

1.6. Резидент эмчийн ажлын байр нь Засгийн газрын 2019 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээ”-ний ТҮЭМ-4 зэрэглэлд хамаарна.

1.7. Резидент эмч нь ажиллан суралцах явцдаа зоонозын өвчний эмнэл зүй, тархвар судлалын мэдлэг, ур чадвар, хандлага эзэмшинэ. Ажиллах цаг нь долоо хоногт 30 хүртэл байх бөгөөд бие даалтын цаг нь ажиллан суралцах цагт хамаарахгүй болно. Бие даалтаар мэргэжлийн эмч эсвэл удирдагч багшийг дагалдан жижүүр хийх, тархвар судлалын хуудастай ажиллах, бичил амь судлалын шинжилгээ уншиж эмчлэгч эмч, удирдагч багшид танилцуулан, баталгаажуулах, мэргэжлийн хичээлийг гүнзгийрүүлэн судлах, тайлан хамгаалалт, мэргэжлийн зөвлөгөөн, хурал, эмгэг судлалын зөвлөгөөн, байгууллагын эмч нарын хуралд танилцуулах илтгэл, мэдээлэл бэлтгэх, тасаг, нэгжийн тойролтод тогтмол оролцох, эмнэл зүйн тохиолдол, тойрон үзлэгт өвчтөний эмнэл зүйн танилцуулга бэлтгэх, судалгаа, мэдээлэл сургалт сурталчилгаа хийх, эмчилгээний болон оношилгооны шинэ арга технологи санаачлах, оношилгоо эмчилгээний стандарт, эмнэл зүйн удирдамж боловсруулахад оролцох, шалгалтад бэлтгэх зэрэг болно.

1.8. Үндсэн мэргэшлийн сургалтын бүртгэл, элсэлт, төгсөлтийн үйл

ажиллагаа нь Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан “Төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтын элсэлт, төгсөлтийн шалгалтын журам”-аар зохицуулагдана.

Хоёр. Сургалт эрхлэх байгууллагын эрх, үүрэг

2.1. Сургалт эрхлэх байгууллага нь дараах бүтцийг бүрдүүлж ажиллана.

2.1.1 Сургалтын хяналтын зөвлөлтэй байна.

2.1.2 Сургалтын хяналтын зөвлөл нь сургалт эрхлэх байгууллагын шууд удирдлаган дор ажиллах бөгөөд сургалт хариуцсан нэгж, үндсэн мэргэшлийн алба, тасаг, чанарын алба, захиргааны алба, эмнэл зүйн сургагч багш, резидент эмчийн төлөөлөлтэй байна.

2.1.3 Сургалтын хариуцсан нэгж: Сургалтын менежер, сургалтын хэрэгжилт хариуцсан ажилтантай байна.

2.1.4 Сургалт удирдах баг: Албадын дарга, тасгийн эрхлэгч, эмнэл зүйн сургагч багш, эмнэлгийн бусад мэргэжилтэн байна.

2.2. Сургалт хариуцсан нэгж нь дараах байдлаар ажиллана.

2.2.1 Сургалтын хөтөлбөрийн хэрэгжүүлэхэд шаардлагатай төлөвлөгөө гаргах, сургалтын хөтөлбөрт хяналт тавих, эмнэл зүйн сургагч багшид чиглэсэн сургалт зохион байгуулах, резидент эмчийн нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэх;

2.2.2 Сургалтын менежер нь сургалтын хөтөлбөрийн төлөвлөгөө, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана. Резидент эмч тус бүрийн мэдээллийг нэгтгэх, резидент эмч нарт зөвлөгөө өгч ажиллана.

2.2.3 Сургалт хариуцсан нэгжийн сургалтын хэрэгжилт хариуцсан ажилтан тухайн байгууллагын үндсэн, төрөлжсөн мэргэшлийн сургалтын үйл ажиллагаанд хяналт тавиж ажиллах ба сургалтын хяналтын зөвлөлийн гишүүн байна.

2.3. Сургалт удирдах баг дараах байдлаар ажиллана.

2.3.1 Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрсөн “Эмнэл зүйн сургагч багш бэлтгэх сургалт” дуургэсэн эмнэл зүйн сургагч багш резидент эмчийн эмнэл зүйн багшаар ажиллана.

2.3.2 Алба, тасгийн эрхлэгч тойролтоор хуваарилагдсан резидент эмчийг эмнэл зүйн сургагч багшид хуваарилах, сургалтын явц, явцын үнэлгээ, эмнэл зүйн сургагч багшийн үйл ажиллагаанд хяналт тавьж, арга зүйгээр хангаж ажиллана.

2.3.3 Эмнэл зүйн сургагч багшийн туслахаар ахлах дамжааны резидент эмч ажиллаж болох ба эмнэлзүйн сургагч багшийн хяналт,

удирдлаган дор резидент эмчид зааж сургана.

2.4. Үндсэн мэргэшлийн сургалтыг эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлөөр батлагдсан тухайн мэргэшлийн чиглэлийн сургалтын хөтөлбөрийн дагуу төлөвлөгөө гарган тасралтгүй зохион байгуулах, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрт тусгагдсан эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар (гардан үйлдлийн жагсаалт, давтамж), хандлагыг тухайн тойролт тус бүрээр ялгаатай төлөвлөх;

2.5. Сургалт эрхлэгч байгууллага нь ажлын албанаас гаргасан шийдвэрээр үндсэн мэргэшлийн сургалтад элссэн резидент эмчтэй байнгын ажлын байранд үндсэн мэргэшлийн сургалтын хугацаагаар хөдөлмөрийн гэрээ байгуулан цалин олгож, суралцах нөхцөл боломж, хамгаалах хувцас хэрэглэлээр хангах;

2.6. Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусlamж үйлчилгээний тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, эмчилгээ оношилгооны удирдамж, стандарт, халдвар хамгааллын дэглэмийг мөрдөх, хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, сургалтын хугацаанд идэвхтэй, үр дүнтэй суралцахыг резидент эмчээс шаардах, гэрээний биелэлтийг дүгнэх, урамшуулах, хариуцлага тооцох;

2.7. Мэргэшсэн эмчийн шууд хяналт, удирдлага доор резидент эмчийн үйл ажиллагааг сургалтын батлагдсан хөтөлбөрт тусгагдсан эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлагын агуулгатай нийцүүлсэн байх;

2.8. Резидент эмчийн үйлчилүүлэгчид бие даан үзүүлэх болон мэргэшсэн эмчийн шууд хяналт, удирдлага доор үзүүлэх тусlamж үйлчилгээг хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтод тусгах;

2.9. Үндсэн мэргэшлийн сургалтын үйл ажиллагаатай холбоотой зардлыг байгууллагын төсөвт жил бүр тусгах;

2.10. Эмнэлгийн удирдлагын шийдвэрээр резидент эмчийг удирдах багшийг томилж, ажиллах тасаг, нэгжийг хуваарилах;

2.11. Үндсэн мэргэшлийн сургалтад явцын хяналт, үнэлгээг тогтмол хийж, сургалтын үйл ажиллагааны тайланг Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлж, дүгнэлт хийж ажиллах;

2.12. Резидент эмчийн суралцах хугацаанд суралцаж буй мэргэжлийн чиглэлийг өөрчлөхгүй байх;

2.13. Резидент эмчийн сургалтын дэвтэр \Logbook\ ийг батлагдсан загварын дагуу мэргэжлийн чиглэл бүрээр боловсруулан гаргаж, резидент эмч бүрийг сургалтын дэвтрээр хангах;

2.14. Эрүүл мэндийн тухай хуулийн 29 зүйлийн 29.6-д заасны дагуу резидент эмчийг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд төлбөргүй хамруулах;

2.15. Суралцагчдын сургалтын явцад тойролт бүрийн төгсгөлд явцын үнэлгээ хийх бөгөөд явцын үнэлгээгээр хангалттай үнэлэгдсэн суралцагчийг дараагийн

тойролт руу шилжүүлэн сургах, сургалтын төгсгөлд хөтөлбөрийн багц цагийг бүрэн, хангалттай хангаж, төгсөлтийн шалгалтад оруулахыг тодорхойлон, дүнгийн хуудасны хамт ажлын албанд хүргүүлэх;

2.16. Сургалтын явцын үнэлгээгээр хангалтгүй үнэлэгдвэл сургалтыг нөхөн суралцуулж, явцын дахин үнэлгээнд 1 удаа хамруулна. Явцын дахин үнэлгээнд дахин хангалтгүй үнэлэгдвэл сургалтаас түр хугацаагаар чөлөө олгох;

2.17. Энэ журмын 2.14 дэх заалтын дагуу сургалтаас түр хугацаагаар чөлөө авсан суралцагч сургалтанд үргэлжлүүлэн суралцахдаа явцын үнэлгээнд хангалтгүй үнэлэгдвэл сургалтаас бүрэн чөлөөлөх тухай саналыг Эрүүл мэндийн хөгжлийн төвд гаргах;

2.18. Резидент эмчээс ажиллан суралцахтай холбоотой гаргасан санал, хүсэлт, гомдол, талархалыг хүлээн авч, судлан, шийдвэрлэх, эргэн мэдээлэх, шаардлагатай бол холбогдох газарт уламжлан шийдвэрлүүлэх;

2.19. Резидент эмчийг хэт ачаалалтай ажиллуулах, дараалсан өдрүүдэд жижүүрт гаргах зэргээр анхаарал суралцуулж, алдаа гаргах нөхцөл бүрдүүлэхгүй байх, ажлын ачааллыг зохицуулах, ажлын байрны тодорхойлолтод тусгагдаагүй, суралцах үйл явцтай нь шууд холбоогүй үүрэг даалгавар өгөхгүй байх;

2.20. Нийтийг хамарсан гамшгийн нөхцөл байдал үүсэх, халдварт өвчний цар тахал гарах, онц байдал, гамшгийн үеийн бэлэн байдал зарлагдсан тохиолдолд Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр суралцагчийг дайчлан ажиллуулах;

2.21. Резидент эмч нь сургалтын төгсөлтийн шалгалтад тэнцсэн тохиолдолд сургалтын хугацаа дуусч, хөдөлмөрийн гэрээг цуцлах бөгөөд төгсөгчдийг ажлын байраар хангахгүй;

Гурав. Сургалт удирдах мэргэшсэн эмчийн эрх, үүрэг

3.1. Мэргэшсэн эмч нь Эрүүл мэндийн тухай хуулийн 28 дугаар зүйл, Эмнэлгийн тусlamж үйлчилгээний тухай хуулийн 22 зүйлийн 22.1 дүгээр зүйлд заасан эмнэлгийн мэргэжилтний эрх эдэлж, үүрэг хүлээнэ;

3.2. Сургалт удирдсан хичээлийн цагийг тооцон ажлаа үнэлүүлэх, сургалт удирдсан ажлын хөлс урамшуулал авах;

3.3. Суралцах явцад сургалтын хөтөлбөрийг бүрэн хангах, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, эмчилгээ оношилгооны удирдамж стандарт, халдварт хамгааллын дэглэмийг мөрдөх, сургалтын хугацаанд идэвхтэй, үр дүнтэй суралцахыг резидент эмчээс шаардах;

3.4. Сургалтын үйл ажиллагаатай холбоотой аливаа санал, хүсэлт, гомдлыг өөрийн байгууллага болон холбогдох дээд байгууллагад гаргах, шийдвэрлүүлэх, хариу авах зэргийг шат дараатай эдлэх;

3.5. Резидент эмчийн үйлчилгээний бие даан үзүүлэх тусlamж үйлчилгээнд

ЭМЧ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТЭН ХООРОНДЫН ёС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭГ БАРИМТЛАН ХАМТРАН АЖИЛЛАХ;

3.6. Резидент эмчид мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвар, харилцаа хандлага, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг баримтлан, үлгэрлэх;

3.7. Сургалт удирдсан үндсэн мэргэшлийн сургалтыг багц цаг бүрдүүлэлтээр тооцуулах;

3.8. Үндсэн мэргэшлийн сургалтын хөтөлбөр төлөвлөгөөний дагуу резидент эмчид онолын болон эмнэл зүйн дадлага сургалтыг удирдан явуулж, тасралтгүй сургах;

3.9. Резидент эмчийн сургалтын явцыг тойролт бүрийн төгсгөлд үнэлгээний шалгуурын дагуу бодитой үнэлж, сургалтын дэвтэр \Logbook\ тухай бүр тэмдэглэн баталгаажуулах, багц цагийн биелэлт, үнэлгээний бодит байдлыг бүрэн хариуцах;

3.10. Мэргэшсэн эмчийн шууд хяналт, удирдлага доор резидент эмчийн сургалтын хөтөлбөрт тусгагдсан үйлчлүүлэгчид үзүүлэх тусlamж үйлчилгээг өөрийн шууд хяналт, удирдлага доор хийлгэх;

3.11. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулахад оролцох;

3.12. Өөрийн шууд хяналт, удирдлага доор резидент эмчийн үйл ажиллагаа, шинжилгээ, оношилгоотой холбоотой мэргэжлийн алдаа, ажлын хариуцлага алдсан нь тогтоогдсон тохиолдолд зохих хариуцлага хүлээх;

Дөрөв. Резидент эмчийн эрх, үүрэг:

4.1 Резидент эмч нь Эрүүл мэндийн тухай хуулийн 28 дугаар зүйл, Эмнэлгийн тусlamж үйлчилгээний тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 заалт, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/337 дугаар тушаалын 1-р хавсралтад заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ;

4.2 Сургалт эрхлэх зөвшөөрөл бүхий байгууллагатай тухайн ажлын байранд үндсэн мэргэшлийн сургалтын хугацаагаар хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажиллах, суралцах орчин нөхцөл, хамгаалах хувцас хэрэглэлээр хангагдах, ажлын гүйцэтгэлд үндэслэсэн цалин хөлс авах;

4.3 Сургалтын батлагдсан цөм хөтөлбөр төлөвлөгөөний дагуу сургалтын хугацаанд эзэмшивэл зохих мэдлэг, ур чадвар, хандлагад тасралтгүй, идэвхтэй, үр дүнтэй суралцах;

4.4 Сургалтын явцын үнэлгээгээр хангалтгүй үнэлэгдвэл сургалтыг нөхөн суралцах, явцын дахин үнэлгээнд 1 удаа хамрагдах, явцын дахин үнэлгээнд хангалтгүй үнэлэгдвэл сургалтаас түр хугацаагаар 1 удаа чөлөө авах;

4.5 Резидент эмчийн сургалтын дэвтэр \Logbook\ ээр хангагдан, сургалтын хөтөлбөрийг биелүүлсэн хугацаа, үнэлгээ, гардан үйлдлийн гүйцэтгэл бусад мэдээллийг хөтлөх зааврын дагуу тухай бүр хөтлөн, удирдагч багшаар

баталгаажуулан, сургалтын нэгжээр хянуулж байх;

4.6 Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.6-д заасны дагуу эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд төлбөргүй хамрагдах;

4.7 Сургалтын үйл ажиллагаатай холбоотой аливаа санал, хүсэлт, гомдлыг суралцагч байгууллага болон холбогдох дээд байгууллагад гаргах, шийдвэрлүүлэх, хариу авах зэргийг шат дараатай эдлэх;

4.8 Сургалтын үйл ажиллагаатай холбоотой /сургалтын чанар, ажиллан суралцах орчин нөхцөл, сургалт удирдагч багшаа сонгох, өөрчлөх, шилжилт хөдөлгөөн/ санал, хүсэлт, гомдлыг суралцагч байгууллага болон холбогдох дээд байгууллагад гаргах, шийдвэрлүүлэх, хариу авах зэргийг шат дараатай эдлэх;

4.9 Ажиллан суралцах явцад Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусlamж үйлчилгээний тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, эмчилгээ оношилгооны удирдамж, стандарт, халдварт хамгааллын дэглэмийг мөрдөж, хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, мэргэжлийн алдаа, дутагдал гаргахгүй ажиллах;

4.10 Эмнэлгийн удирдлагын шийдвэрээр томилогдсон удирдах багшаар удирдуулан, хуваарилагдсан тасаг, нэгжид ажиллах;

4.11 Хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, ажлын байрны тодорхойлолтод заасан ажлын чиг үүргийг гүйцэтгэх;

4.12 Үйчлүүлэгчид бие даан үзүүлэх тусlamж үйлчилгээнд эмч, эмнэлгийн мэргэжилтэн хоорондын ёс зүйн хэм хэмжээг баримтлан хамт олонтой хамтран ажиллах;

4.13 Резидент эмчийн үйчлүүлэгчид бие даан үзүүлэх тусlamж үйлчилгээтэй холбоотой мэргэжлийн алдаа, ажлын хариуцлага алдсан нь тогтоогдсон тохиолдолд зохих хариуцлага хүлээх;

4.14 Мэргэшсэн эмчийн шууд хяналт, удирдлага доор резидент эмчийн үйлчилгээ үзүүлэх, шинжилгээ, оношилгоог мэргэшсэн эмчийн шууд хяналт, удирдлагагүй хийх эсвэл мэргэшсэн эмчийн заавраас өөрөөр хийх, дур мэдэн нууцаар хийхтэй холбоотой мэргэжлийн алдаа, ажлын хариуцлага алдсан нь тогтоогдсон тохиолдолд зохих хариуцлага хүлээх;

4.15 Эмнэлгээс зохион байгуулсан эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцох, илтгэл мэдээлэл хэлэлцүүлэх, мэдлэг мэргэжлээ тасралтгүй дээшлүүлэх;

4.16 Суралцах хугацаанд суралцаж буй мэргэжлийн чиглэлийг өөрчлөхгүй байх;

4.17 Сургалтын явцад тойролт, улирал, дамжаа бүрийн төгсгөлд явцын үнэлгээнд хамрагдан хангалттай үнэлэгдвэл дараагийн тойролт, дамжаанд шилжин суралцах, сургалтын төгсгөлд хөтөлбөрийн багц цагийг бүрэн, хангалттай

хангавал төгсөлтийн шалгалтад орох;

4.18 Нийтийг хамарсан гамшгийн нөхцөл байдал үүсэх, халдварт өвчний цар тахал гарах, онц байдал, гамшгийн үеийн бэлэн байдал зарлагдсан тохиолдолд Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр дайчлагдан ажиллах;

4.19 Хууль, тогтоомжид заасан бусад эрх, үүрэг;

Тав. Сургалтаас түр чөлөө олгох, чөлөөлөх, шилжилт хөдөлгөөн

5.1. Сургалтын алба нь сургалтаас чөлөө олгох, чөлөөлөх шийдвэрийг сургалтын хяналтын зөвлөлд танилцуулан сургалт эрхлэх байгууллагын захирлын шийдвэрээр баталгаажуулж, Эрүүл мэндийн хөгжлийн төвд тухай бүрт хүргүүлнэ.

5.2. Резидент эмчийг дараах үндэслэлээр 1 жил хүртэл хугацаагаар сургалтаас чөлөө олгож болно.

5.2.1. Жирэмсний болон амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй,

5.2.2. Цэргийн жинхэнэ алба хаасан, энхийг сахиулах ажиллагаанд оролцсон,

5.2.3. Өөрийн болон гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндийн байдлын улмаас эмчлүүлж сувилуулсан,

5.2.4. Эмнэлгийн шинжилгээ хийлгэсэн, донорын үүрэг гүйцэтгэсэн,

5.2.5. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн дагуу хамгаалалтын арга хэмжээнд хамрагдсан,

5.2.6. Явцын шалгалтад давтан хангалтгүй үнэлэгдсэн, төгсөлтийн шалгалтад орох эрх үүсээгүй,

5.3. Сургалтаас чөлөөлөгдсөн резидент эмч үргэлжлүүлэн суралцах хүсэлтээ чөлөөний хугацаа дуусахаас ажлын 10-аас доошгүй хоногийн өмнө сургалт хариуцсан нэгжид гаргах бөгөөд сургалтын төлбөр болон сургалтын хөтөлбөрийн тооцоо байхгүй тохиолдолд сургалт эрхлэх байгууллагын захирлын шийдвэрээр үргэлжлүүлэн суралцаж болно.

5.4. Резидент эмчийг дараах тохиолдолд сургалтаас хасна.

5.4.1. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 1 ба түүнээс дээш сар хүртлэх хугацаанд сургалтаас завсардсан,

5.4.2. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн ноцтой зөрчил гаргасан,

5.4.3. Өөрийн хүсэлтээр сургалтаас татгалзсан,

5.4.4. Хөтөлбөрийн агуулгыг хугацаанд нь дүүргээгүй,

5.4.5. Албан ёсоор чөлөө аваагүй, чөлөө авсан хугацаандаа эргэж ирээгүй,

5.5. Богино хугацааны сургалтын чөлөөг байгууллагын дотоод журмын

хүрээнд зохиоцуулна.

5.6. Чөлөө авсан тохиолдолд сургалтын хөтөлбөрийг нөхөх төлөвлөгөөг гаргаж сургалтын албанад танилцуулана. Сургалтын хөтөлбөрийг нөхөх төлөвлөгөөг эмнэлзүйн багш, резидент эмч хамtran гаргаж баталгаажуулсан байна.

5.7. Сургалтаас чөлөөлөгдсөн, чөлөө авсан резидент эмч сургалтын зөрүүг төлбөртэйгөөр нөхөн суралцаж тухайн тойролтын тооцоо дууссан тохиолдолд дараагийн тойролтод суралцуулна.

Зургаа. Хариуцлага

6.1. Резидент эмч нь хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, байгууллагын дотоод журмыг зөрчсөн тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

6.2. Сургалт удирдагч эмнэл зүйн сургагч багш, резидент эмч нь хуульд заасан үүргээ биелүүлээгүй бол Зөрчлийн тухай хуулийн 6.8-д заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Долоо. Сургалтын үнэлгээ

7.1. Резидент эмчийг сургалтын явцын болон төгсгөлийн үнэлгээгээр үнэлнэ.

7.2. Явцын үнэлгээг сургалт эрхлэх байгууллага үнэлэх бөгөөд үнэлгээгээр хангалттай үнэлэгдсэн суралцагчийг дараагийн тойролт, улирал, дамжаанд шилжүүлэн сургана. Явцын үнэлгээг мэдлэг, ур чадвар /асуумж бодит үзлэг хийх чадвар, гардан үйлдэл, шинжилгээ, эмчилгээний төлөвлөлт, ялан оношилгоо, өвчтөнд үзүүлэх тусламж, үйлчилгээ/, хандлага /харилцаа, хариуцлага, хүндэтгэл/, ирц, идэвхи оролцоо, тайлан хамгаалалт, илтгэл мэдээлэл, жижүүр хийсэн үнэлгээ зэргийг хамааруулан тооцно.

7.3. Резидент эмчийн сургалтын үнэлгээг дараах байдаар тооцно. Үүнд:

Үсгэн дүн	Тоон дүн	Хувилсан дүн	Чансаа
A	4	90-100%	Сургалтын дээд амжилтыг илтгэх дүн
B	3	80-89%	Дундаж төвшнөөс дээгүүр амжилтыг илтгэх дүн
C	2	70-79%	Дундаж төвшний дүн
D	1	60-69%	Дундаж төвшнөөс доогуур амжилтыг илтгэх дүн /Хангалтгүй/
F	0	59% бага	Хангалтгүй дүн

7.4. Тойролтын явцад D, F үнэлгээ авсан тохиолдолд байгууллагын дотоод

журмын дагуу эмнэлгийн удирдлага суралцагчийн цалинг тодорхой хувиар бууруулна.

7.5. Резидент эмчийн мэдлэг, ур чадвар, хандлагын түвшинг үнэлэхдээ үнэлгээний оновчтой арга хэлбэрийг ашиглаж болно.

7.6. Хөтөлбөрийн шаардлагыг 80% ба түүнээс дээш хангасан тохиолдолд төгсөлтийн шалгалтад оруулна.